



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/195

Улаанбаатар хот

**Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэчийг
сонгон шалгаруулах Үнэлгээний хороо
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/961 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай үйлдвэрлэл технологийн паркийн авто зам, дулаан хангамж, инженерийн шугам сүлжээ, тунелийн систем, ус хангамж, ариутгал татуургын дотно гадна зураг төслийн ажлуудын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: О.Содовжамц

Худалдан авах ажиллагааны албаны дарга

Гишүүд: Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

С.Пүрэв-Очир

Багахангай Үйлдвэрлэл, технологийн парк УТҮГ-ын Хөрөнгө оруулалтын менежер

Д.Даваасамбуу

1 дүгээр хорооны иргэн

Нарийн бичиг

Э.Урансайхан

Худалдан авах ажиллагааны албаны
Худалдан авах ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн

2.Хууль тогтоомжийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/961 дүгээр захирамжийн хавсралтын 1-4 дэх заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (О.Содовжамц)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД